

МОНГОЛ ХЭЛНИЙ ЯЗГУУР МОРФЕМЫН  
R ГИЙГҮҮЛЭГЧИЙН СУГАРАХ ТУХАЙ

Е. В. Сундуева \*

Түрэг хэлнүүдэд хэлний үзүүрийн чичрэх *r* гийгүүлэгч сугарах нь тогтвортой үзэгдэл биш, ихэвчлэн ярианы хэлэнд тохиолддог тухай Э.В.Севортян батлан бичжээ. Энэ авиа сугарах түүхэн баримтуудын дунд: аз. *гумармаг* // бичгийн хэлбэр *гуртармаг* ‘дүүргэх, дуусгах’, турк. *pek* ← *berk* ‘маш, их, тун’, *pekitmek* ← *berkitmek* ‘бэхжүүлэх’, турк ярианы хэлэнд *aslan* ‘арслан’, *göz kirpmak* ‘нүдээ онийлгох’, ‘ирмэх’; аз. *би(р)чох* ‘олон хүн’, ‘эгнээ’; турк. *bi(r)az (biraz)* ‘бага зэрэг, бага сага’, *bi(r)şey (birşey)* ‘нэг юм, ямар нэг юм’, *bi(r) daha (bir daha)* ‘дахин’, *bi(r)de (bir de)* ‘ахиад’ гэх мэт хэлбэрүүд тохиолдоно [Севортян, 1955, х. 270].

Якут хэлэнд *r* гийгүүлэгч *t*-гийн өмнө (*там* < *тарт* ‘татах’, *түөт* < *түөрт* ‘дөрөв’, *бэм* < *бэрт* ‘маш, тун, үлэмж’), зарим тохиолдолд тэсрэх *k* гийгүүлэгчийн өмнө сугардаг (кирг., узб. *бек* // каз., түркм. *берк* ‘бөх, бэх’) тухай эрдэмтэн Б.М.Юнусалиев [Юнусалиев, 1966, с. 30] дурдсан байдаг.

Монгол хэлнүүдэд үеийн эцэст *\*t*, *\*č*, *\*ʒ* буюу *\*s* гийгүүлэгчийн өмнөх *\*r* авиа сугардаг тухай эрдэмтэн Н.Н.Поппе тэмдэглэсэн байдаг. Мөн “монгол бичгийн хэл болон ярианы хэлэнд үгийн адгийн *r* гийгүүлэгч *-sun* дагаврын өмнө сугардаг. Жишээлбэл: монг. *toyosun* < *\*toɣar-sun*, *öber-sed* < *\*öber-süd* ~ *öbesüd*, *jesün* < *\*jer-sün*” [Poppe, 1987, p. 161–162].

Бас *n*, *r*, *l*, *s* гийгүүлэгчээр төгссөн язгуурт *-sun* дагавар залгахад төгсгөлийн гийгүүлэгч гээгддэг үзэгдлийн тухай эрдэмтэн Г.Й.Рамстедт тэмдэглэжээ. Жишээ нь: *dajin-sun* ~ *dajisun*, *kimul-sun* ~ *kimusun* [Рамстедт, 1957, х. 199] гэх мэт. Энэ үзэгдэл буриад, монгол, дунсян хэлэнд буйг В.И.Рассадин ажигласан байна [Рассадин, 1982, х. 153–156]. Тэрээр өөр нэгэн бүтээлдээ бур. *ундан* // *умдан*, хальм. *умср*, *умср-*, сонг. бич. монг. *umba-* зэрэг үгээс *\*um* ‘ус уух, залгих’ гэсэн язгуур гаргаж, үүнээс *\*umsun* ‘ус’ (‘ууж байгаа юм’) гэсэн үг үүсчээ хэмээн бичсэн байна. Хожим *\*m* гийгүүлэгч нь гээгдэж эдүгээгийн олон монгол хэлэнд тухайлбал, бур. *уһан*, монг. *ус*, хальм. *усн*, дунс. *уеу* гэсэн хэлбэртэй болсон аж. Сэргээн тогтоосон *\*umsun* ‘ус’ хэлбэрийг маньж-түнгүүс хэлний *om-* // *um-* ‘уух’ хэмээх үйл үгтэй харьцуулж болно [Рассадин, 2008, х. 166–167] гэжээ. Тэрээр эдгээр жишээ баримтаар сонсголт авиа шуугиант гийгүүлэгчийн өмнө гээгдэх зарчмыг баталсан байна. Энэ зарчим хэлний хөгжлийн

\* Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, бурхан шашин, төвд судлалын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн тасгийн эрхлэгч, хэл бичгийн ухааны доктор

эртний шатанд (*mölsün* > монг. *мөс*, *moylsun* < бар.-бур. *мойһон* ‘мойл’ г.м.) нилээн идэвхтэй байжээ.

Дээр дурдсан *usun* хэмээх үгээс *\*ursun* гэх эртний хэлбэрийг нь сэргээж болно. Энэ *\*urs* язгуур нь дунд. үе. монг. *oros-* [LH], *urus-* [MA 368], сонг. бич. өмнөх монг. *urus-* [Tum. 608], сонг. бич. монг. *urus-* [Kow. 454], монг. *урса-*, бур. *урда-*, хальм. *урс-*, Шинж. ойр. *урас-*, орд. *urus-*, даг. *orsu-*, дунс. *usuru-*, *urusu-*, ш.-уйг. *urus-*, *urusu-*, *usuru-*, монгол. *urosə-* ‘ямар нэгэн чигт асгаран, цутган хөдлөх’ [EDAL 1063] гэдэг үйл үгэнд дайралдах ба анх *\*urs / \*sur / \*jur / \*sar / \*šor* авиа дуурайх үг байжээ. Жишээ нь, сонг. бич. монг. *јir-јir* ‘булгийн хүржигнээ’ [Kow. 2358], дунд. үе. монг. *šarkira-* [MA 331], сонг. бич. монг. *šargiya-*, монг. *шаргуа-*, бур. *шарья-* ‘гол усны дуугарах’; сонг. бич. монг. *šorјigina-*, *šorčigina-*, монг. *шоржигно-*, *шорчигно-*, бур. *шорьё-*, хальм. *шорјқңн-*, Шинж. ойр. *шорјқиңна-*, бур. *шорхир-*; бур. *шуршагана-*, *шурья-* ‘уснаас шор шор гэсэн чимээ сонсдох’; бич.-монг. *sarki-*, монг. *сархий-* ‘срр! (цалгиа, шоржигноо дуурайх үг)’, бур. *һарья-* ‘хоржигнон урсах’, *сарса-* ‘цацах, үсэргэх’, бур. *сорьё-* ‘оргилон гоожих’; дунд. үе. монг. *sürči-* [MA 99], сонг. бич. өмнөх монг. *sürči-* [Tum. 557], сонг. бич. монг. *sürči-* [Kow. 1435], монг. *сүрчи-*, бур. *сүршэ-* ‘цавдах’, бао. *чур-* ‘ус зэрэг шингэн зүйлийг юман дээр сацах, шүрших’; сонг. бич. монг. *usun-iyar čarda-* ‘усаар түсэргэх’ [Kow. 2114] гэх мэт. Эрдэмтэн Г.Рамстедт тус үгийн *\*u* язгуур хүннү хэлэнд *u* ‘ус’, гольд. *uáta*, түнг. *ūakta*, лам. *óta* ‘давалгаа’, монг. *u-gi-ya-* ‘угаа-’ үгсийн язгууртай адил гаралтай гэж бичжээ [Рамстедт, 1957, х. 199].

Сонг. бич. монг. *serјim*, монг. *сэржим*, бур. *сэржэм* үгийн *\*serј* язгуур нь бас бурханд өргөж байгаа зүйлийн (архи, сүү, цай г.м.) цавдах (сүрших)-ын авиа дуурайх утгатай гэж бодож байна. Түрэг хэлнүүдэд *serп-* ‘асгах, цалгих; цацах, сүрших’ үйл үг байна [ЭСТЯ, 2003, с. 264]<sup>1</sup>.

Сүршихийн авиа дуурайх язгуур *\*sürč* түнгүүс-маньж хэлнүүдэд эвэнк. *сарги-* ‘хоржигнох’, нан. *сарги-* ‘олон загасны цалгих’; манж. *сар сир сэмэ* ‘цалгиж’; ульч. *сар-р*, нан. *соар-соар* ‘цалгиатай’; *соролто-* ‘оргилон гоожих (цусны тухай)’; эвэнк. *чир сэмэ* ‘чулуунуудын дундуур нэвтрэн (усны тухай)’; ульч. *чорју-* ‘гоожин, савиран’, манж. *чор сэмэ* ‘бургилан, оргилон’, нан. *чорони* ‘усны эргүүлэг, усны уйл’ үгс байна.

Дунд. үе. монг. *čisun* [SH, MA], сонг. бич. монг. *čisun*, монг. *цус*, бур. *шухан*, хальм. *цусн*, Шинж. ойр. *цусан*, орд. *јису*, мог. *čusun*, даг. *čos*, *čose*, дунс. *čusun*, бао. *čisoŋ*, ш.-уйг. *čusun*, *čusən*, монгол. *сэзи*, *сэжэ* ‘бүх биеийн эсийг тэжээл ба эдийн солилцоогоор хангадаг, бие махбодын дотуур гүйх шингэн улаан зүйл’ хэмээх үгийн *\*čirs-un* анхны хэлбэрийг сэргээж *\*čirs* язгуур нь цусны оргилон гоожих, үсрэх авиаг дуурайж үүссэн үг байж магадгүй. Эрдэмтэн М. Базаррагчаа «*čirā-i* (царай), *čirā-yi-* (чарайх), *či-r-mā-yi-* (чармайх), *či-ra-mā* (чармай нүцгэн), *či-ra-mā-* (чармах) зэрэг үгс нь “өргөх, чирэх зэрэгт чармайн зүтгэж, нүүр царай улайх, судас шөрмөс гүрдийх” гэсэн үйлийг үүсгэжээ. Ийм “царайд улаан туяа татах, нүүр царай, өнгө зүс” гэсэн утга бий болж, нэр бүтээх *-su-n* дагаврын өмнө орсон *ra-* үе – утгалбар гээгдэж *či-(ra)-su-n* хэмээх хэлбэрээс *či-su-n* (цус) хэмээх үг бүтнэ» гэж бичжээ [Базаррагчаа, 2012, х. 44]. “Etymological dictionary of Altaic languages” гэдэг толинд өвөг монгол *\*čisu* өвөг түнгүүс-манж. *\*јин-* ‘судас, цусны судас’; өвөг түрэг *\*dīn* ‘амьсгал; амралт; амрах; бүгтрэх, амсгаадах; амьсах; амгалан; бүгчим’, өвөг япон *\*ti* ‘цус’ хэлбэрүүдтэй харьцуулсан [EDAL 401–402] байна.

<sup>1</sup>) Сонг. бич. монг. *čača-*, монг. *цац-*, бур. *саса-*, хальм. *цац-* ‘сүрших’ (> *čarča-*) гэдэг үйл үгэнд бас язгуурын *r* сугарсан.

Сонг. бич. монг. *yosun*, монг. *ёс*, бур. *ёһо*, хальм. *йосн*, Шинж. ойр. *йосон* ‘юмны зайлшгүй зүй тогтоол, жам тавилан’ (< \**yorsun*) авиа дуурайх \**yor-* гэдэг үйл үгээс үүссэн үг болов уу гэж таамаглаж байна. Тус үйл үгийг сонг. бич. монг. *yorgi-*, монг. *ёрги-* ‘бардах, сайрхах’; сонг. бич. монг. *yari-* [Less. 429], монг. *яри-*, бур. *яри-*, Шинж. ойр. *йара-* ‘хэлэх’, хальм. *яр-яр ги-* ‘үг солилцох, хөөрөлдөх’, бур. *яр-яр дуугар-* ‘аягүй дуугаар хэлэх’, *ярд гэ-* ‘янгинасан дуугаар хэлэх’; сонг. бич. монг. *yargi-*, монг. *ярги-* ‘шуугилдах, хашгиралдах’; сонг. бич. монг. *yarki-*, монг. *ярхий-* ‘маргах, хэрэлдэх’; *ёрд-ёрд гэлдэ-* ‘тасалдсан, янгиа дуугаар ярих’; сонг. бич. монг. *яру-*, монг. *зар-* ‘чанга хашгирч’ юм худалдах’, *jorgilya-* ‘өндөр дуугаар дуудах’ [Kow. 2301, 2406], монг. *зоргилго-* ‘хашгарах, чарлах’ г.м. үгтэй харьцуулж болно. Эдгээр үгийн утгаас *yor-* үгийн ‘чанга, өндөр дуугаар хэлэх’ гэдэг утгыг гаргаж болно. Тэгвэл \**yorsun* гэдэг үг нэн түрүүн ‘сонсгол, зарлал’ гэдэг гол утгатай байжээ. Одоо ч ‘хүүрнэх’, ‘шүүмжлэн хэлэх’; ‘сургалт’, ‘номлол, сургаал’ гэсэн утгын нэгжүүд хадгалагдаж байна.

Энэ утга нь сонг. бич. өмнөх монг. *jar* [Tum. 424], сонг. бич. монг. *jar* [Kow. 2300], монг. *зар*, бур. *зар*, хальм. *зар*, Шинж. ойр. *зар* ‘олонд зарлан нийтлэх үг буюу мэдээ бичиг’; дунд. үе. монг. *jarliq* [MA 203], сонг. бич. өмнөх монг. *jarliy* [Tum. 424], сонг. бич. монг. *jarliy* [Kow. 2306], монг. *зарлиг*, бур. *зарлиг* ‘хаан хүний хэлсэн зарласан үг ба бичиг’; сонг. бич. өмнөх монг. *jaray* [Tum. 424], сонг. бич. монг. *jaryu* [Kow. 2305], монг. *зарга*, бур. *зарга*, хальм. *зарһ*, Шинж. ойр. *зарһа* ‘харилцан заалдаж тэмцсэн тэмцэл’ зэрэг үгэнд тодорхой гарч байна. Э.В.Севортяны бодлоор, түрэг. *жар* ~ *йар* ~ *чар* ‘уриа; мэдэгдэх; хашгараан; орилоон’ бас авиа дуурайсан үг бөгөөд харьцуулбал, турк. *carcar* ‘чалчаа’, як. *сар*, ма. *јар* ‘артелийн ямар нэг юм дээшээ өргөхдөө хашгарах дуун’ [ЭСТЯ, 1989, х. 19–20] гэсэн хэлбэртэй байна.

Дүрс дуурайх үг авиа дуурайх үгтэй салшгүй холбоотой гэдэг нь дамжиггүй. Жишээлбэл, \**ar* гэдэг араатан амьтны дуу дуурайх язгуур хүний ухаанд хурц шүд, араа шүдний дүрстэй холбогдож, «дэрийсэн, ёрдойсон, хурц оройтой» [†] гэдэг дүрс төрүүлдэг (*jer, šoru, jiruq-a, siruγ, sarayčün, čerge, serege, sorbi, sariday* г.м.) байна. Энэхүү дүрсийн үндсэн дээр *r* гийгүүлэгчтэй язгууруудад «ондоо ондоо тийш орвойсон, бүрзгэр, сэглэгэр, сэгсгэр» [†] гэдэг дүрс үүсчээ (*orbuyur, arbayar, dereger* г.м.).

Дунд. үе. монг. *xusun* [HY 45, SH], *hason* [IM], *usun* [MA], сонг. бич. монг. *usu(n)* [Less. 1013], монг. *үс(эн)*, бур. *үһэн*, хальм. *үсн*, Шинж. ойр. *үсен*, орд. *usu(n), osu*, даг. *xusu, huse, xus*, дунс. *usun, usun*, бао. *sun*, ш.-уйг. *hasun*, монгол. *fuž, sž* [EDAL 1186] ‘үс; ноос, ангийн арьс; ширүүн хялгас, өргөс’ гэдэг үгсээс \**hürsü(n)* гэдэг анхны хэлбэрийг нь сэргээн тогтоож болно. Язгуурын авианы бүрэлдэхүүний талаас ч, утгын талаас ч орчин үеийн буриад хэлэнд энэ үгэнд хамгийн ойр нь *үрз-гэр* ‘орвойсон’ гэдэг дүрс дуурайх тэмдэг нэр болно (монг. *үрзий-* ‘(өдөө) сэргийлгэх, өрвийх’). “Etymological dictionary of Altaic languages”-ийн зохиогчид өвөг монг. \**hü-sü* ‘үс’, өвөг түнгүүс-маньж. \**riñe-* ‘үс’, өвөг япон. \**ránái* ‘өд’-ийн үндсээс *p’úñe* ‘үс, ноос’ гэдэг өвөг алтай хэлний анхны хэлбэрийг тогтоосон [EDAL 1186] байна.

Гэрлийг хүртэх мэдрэхүйн талаас авч үзвэл, *r* авианы сонсогдох ба өгүүлэгдэх шинж чанарыг илтгэсэн утга нь анхдагч язгуурын утгыг бүрдүүлдэг. Тухайлбал *r* авиалбар нь таарамжгүй сэрэл мэдрэмжийг илэрхийлдэг хэмээн үзэх нь уг авиаг хэлэхэд хэлний үзүүр туушинд түргэн түргэн цохиж, хийн урсгалыг хэд хэд хэрчдэгтэй холбогдоно. Үүнээс өмнө *irya-*, *irayalja-*, *jergelge*, *jirya-* гэдэг үгнүүдэд *r* авиа гэрэл харахад нүдэнд мэдрэгдэх өвчин, тааламжгүй сэрлийг хүргэнэ.

Дунд. үе. монг. *časun* [SH, MA], сонг. бич. монг. *casu(n)* [Less. 166], монг. *цас*, бур. *цаһан*, хальм. *цасн*, Шинж. ойр. *цасан*, орд. *жасу*; мог. *čōsun*, даг. *čas, čase*, дунс. *časun, žansun*, бао. *časоң, čabsoң*, ш.-уйг. *čekseu, čeksen*, монгор. *časə, čaxsə* ‘жихүүн цагт агаарт усан талстууд бий болж цав цайм унгарил ширхгүүдээр буух агаарын тундас, мөнхүү тундас бууж газрын гадаргыг бүрхсэн юм’ гэдэг үг (< *\*čarsun*) сонг. бич. монг. *čargi-*, монг. *царги-* ‘цасны гялалзахаас «сохрох», юм үзэхээ болих’, бур. *һарга-* ‘нарны хурц гэрлээс «сохрох», юм үзэхээ болих’ гэдэг үйл үгтэй харьцуулж болно<sup>2</sup>. EDAL-ийн зохиогчид *\*čiaga* ‘хүйтэн; царцанги цас’ гэдэг өвөг алтай хэлний анхны хэлбэрийг гаргаж, *\*ča(g)-su* ‘цас’ өвөг монгол хэлбэрийг өвөг түнгүүс-маньж *\*čiaga* ‘цар; царлах’, өвөг солонгос *\*čhǎ-* ‘хүйтэн’ хэлбэрүүдтэй харьцуулсан байна. Тэдний бодлоор, монг. *ča-sun* нь бас *\*čar-sun* гэдэг анхны хэлбэртэй байсан байж магадгүй (харьцуул. *\*čar* ‘царцанги цас’) гэж үзсэн байна. Гэхдээ өмнөд монгол хэлнүүдэд нармайн *\*čag-su*-ийн мөр үлдсэн [EDAL p. 436] гэжээ.

Үүнээс гадна, *r* гийгүүлэгч нь ижил төстэй олон жижигхэн зүйлийг харахад үүсдэг аягүйн сэрлийг илэрхийлдэг байна. Жишээлбэл: *јriger* ‘тэгш эгнээ эгнээгээр жагссан’, *јирс јирс хий-* ‘эрээлжих’, *ira јira, јerge, čerig, јarm-a* г.м. Загас, хорхой шавьж гэрлийг сайнаар тольдон тусгадаг гадартай. Наранд гялалзсан тоо тоймшгүй загасыг харахад төрдөг нүдний эрээлж *јir / qar* хэмээх язгуураар илэрхийлэгддэг. Тухайлбал, сонг. бич. монг. *јirayaqai*, монг. *жараахай*, бур. *жараахай* ‘загасны нам, усанд оршино, бие нь маш жижигхэн’; сонг. бич. монг. *јirmayai* ‘загасны түрс’ [Kow. 2369], монг. *жарамгай*, хальм. *јирмэхэ*, Шинж. ойр. *јирмэхэхэ*; п.-мо. *јarm-a јyasu* [Kow. 2305], мо. *зарам загас* ‘жижиг загас’. Түнгүүс-манжуур хэлнүүдэд нан. *пару-пару* ‘үй олоноор (сүрэг загасын тухай)’» [Киле, 1972, с. 145], эвэн. *чарас* ‘таран, бутран, бут үсрэн’ [ССТМЯ, 1977, х. 385] хэмээх үгс байна.

Эрдэмтэн В.И.Рассадины таамаглалаар, сонг. бич. монг. *јyasun*, монг. *загас*, бур. *загаһан*, хальм. *заһсн* ‘хүйтэн цустай, хайрсан арьстай, усанд оршдог, сээр нуруутай амьтны ерөнхий нэр’ хэмээх үг *јrya [јyasun]* ‘цагаан загас’ гэдэг тодорхой загасны нэрээс үүсчээ [Рассадин, 2006, с. 11–12]. Үүнээс өмнө бичсэн нэгэн бүтээлдээ баоань хэлний *дјилгасоң ~ дјиласон* ‘загас’ хэмээх хэлбэрийг үндэслэж, бусад монгол хэлэнд *\*l* авиа бас байсан (*јlyasun* < *\*јl* язгуур + *-ya* дагавар + *-sun* дагавар) гэж таамаглажээ. Тус язгуур түрэг. *јilan // јilan* ‘могой’ бөгөөд *јulyun* ‘сухай’ зэрэг үгсийг бүтээсэн [Рассадин, 1982, х. 94] гэжээ. Тэгэхэд В.И.Рассадины *\*јryasun* хэмээх сэргээн тогтоосон хэлбэрээс ‘гялалзсан, эрээлжилсэн юм’ гэсэн утгатай *\*јir/јirq* язгуурыг гаргаж болно.

Бас [*r*] гийгүүлэгч урт эгшигтэй язгуур морфемд сугарсны жишээ байна. Сонг. бич. монг. *sigüsü(n)* [Kow. 1513], монг. *шүүс*, бур. *шүүһэн*, хальм. *шүүсн* ‘шим’ (> *\*sigürsün*) *\*sigür* гэдэг уруулаар юм сорохын авиа дуурайх язгуураас үүсчээ. Харьцуулбал, бур. *шүүрд гэтэр һоро-*, мо. *шүүр-* ‘нэвтрэх, нэвчих’ г.м. Сонг. бич. монг. *sigesü(n)* [Kow. 1509], монг. *шээс*, бур. *шээһэн*, хальм. *шеесн* ‘бөөрөөр дамжин боловсорч гаргах, бие махбодод хортой шингэн зүйл, ялгадас’ (> *\*sigersün*) *\*siger* гэдэг авиа дуурайх язгуур морфемыг гаргаж болно.

Сонг. бич. монг. *kögesün* [Kow. 2625], мо. *хөөс*, бур. *хөөһэн*, хальм. *көөсн* ‘шингэн юмны дотоодод хий орж цэврүүтэн хөвсөн юм’ хэмээх үг анхан *\*kögersün* хэлбэртэй

<sup>2)</sup> Тус *\*čark/čarg* язгуур морфемоос *\*čaryan* > сонг. бич. монг. *čayan*, монг. *цагаан*, бур. *сагаан*, хальм. *цаһан* ‘юмны цас мэт өнгө, цэгээн’ цасны өнгөтэй холбоотой тэмдэг нэр үүссэн байж магадгүй.

байжээ. Монгол. *körse* ‘хөөс’, монг. *хөөр*- ‘дэгдэх, дээшлэн эчих, дэврэх’ хэмээх үгнүүдэд \**köger* язгуур үлдсэн байна. Богино эгшигтэй \**kör / kür* хий орж байгаа авиа дуурайх язгууртай адилхан утгыг илэрхийлнэ. Энэхүү утга сонг. бич. монг. *kögerge*, монг. *хөөрөг*, бур. *хөөргэ*, *хүрхэ* ‘гал үлээлгэн хөгжөөх зэвсэг’ (бур. *хүрхы*- ‘хий дүүрэх, үлээгдэх, хийлэгдэх, тэсгийх’) хэмээх үгэнд тодорхойлж болно.

Түрэг. *kə:рүк* ‘гал үлээлгэн хөгжөөх зэвсэг’ гэдэг үгийг Г.Рамстедт монгол хэлнээс түрэг хэлнээ орсон үг гэж бодож, монг. *kögerge*-г \**köwer-* / \**köwe-* гэдэг үйл үгээс үүссэнийг тэмдэглэнэ. Л.С.Левитская сонг. бич. монг. \**köwer* ‘үлээх’ хэмээх утгатай үг үүсгэх үндэсийг гаргажээ [ЭСТЯ, 1997, х. 118]. Энэхүү авиа дуурайх утга ‘дотоодод хийгээс ямар нэг цэврүүтэн хөвсөн’, ‘бардам, сайрхаг, ихэрхэг’ дүрс дуурайх утга өөрчилж, олон үгсийг үүсгэжээ. Үүнд: бур. *хүрхигэр* ‘уужим, их зайтай; багтаамжтай’, *хүрхэгэр* ‘дэлгэрсэн, тахаж дэлгэрсэн’, сонг. бич. монг. *kerkeyi-* ‘бардах, бардамнах, сайрхах’ [Kow. 2518], сонг. бич. монг. *körküger*, монг. *хөрхгэр* ‘ихэрхэг’; бур. *һорхогор* ‘их зантай’ г.м. Бас энэ эгнээнд дунд. үе. монг. *körengē* [MA 224], сонг. бич. монг. *körüngge* [Kow. 2640], монг. *хөрөнгө*, бур. *хүрэнгэ* ‘идээний зүйл’; дунд. үе. монг. *öreme* [MA 329], сонг. бич. өмнөх монг. *ört-e* [Tum. 512], сонг. бич. монг. *ört-e, örüm-e* [Kow. 584, 589], монг. *өрөм*, бур. *үрмэ*, хальм. *өрм*, Шинж. ойр. *өрөм*, орд. *орто*, даг. *urum, urume*, ш.-уйг. *ором*, монгол. *jermen, rmēn* [EDAL 1061] ‘хөөрүүлсэн сүүний дээгүүр бүрхэн тогтох тослог идээ’ хэмээх үгсийг оруулж болно.

Язгуур морфемын *r* гийгүүлэгч нэн түрүүнд өгүүлэх эрхтэний хүчдлийн суларснаас гээгдэснийг эрдэмтэд тэмдэглэсэн байна. Эрдэмтэн В.И.Рассадин зарим үгэнд *r* гийгүүлэгч сугарахгүй үлдсэний хоёр шалтгааныг өгүүлсэн байна. Үүнд: 1) зарим үгэнд *r* гийгүүлэгч сугарч амжаагүй (*алирс* г.м.); 2) адил дуудлагатай авианы илүүдлээс зайлсхийхийн тул сугараагүй (*нүүрсэн* гэдэг жинхэнэ нэр өнгөрсөн цагаар тодотгон холбох *-сэн* нөхцөлтэй *нүүрсэн* гэдэг үйл үгтэй нийлэх байсан, бур. *хашарһан* ‘хайрс’ ↔ *хашаһан* ‘шивээлсэн’ г.м.) [Рассадин, 1982, х. 154] гэжээ. Цаашдаа *r* гийгүүлэгчийн сугаралтын явцыг нарийн судалж, бүр олон жишээг илрүүлэх хэрэгтэй байна.

## НОМЗҮЙ

1. Базаррагчаа М. Монгол үгийн гарлыг мөшгих нь. II, – Улаанбаатар, 2012.
2. Базаррагчаа М. Монгол хэлний судлалын зарим асуудал. – Улаанбаатар, 2012.
3. Киле Н. Б. Образные слова нанайского языка. – Л.: Наука, 1973.
4. Рамстедт Г. Введение в алтайское языкознание. Морфология. – М.: Изд-во иност. лит-ры, 1957.
5. Рассадин В. И. Очерки по исторической фонетике бурятского языка. – М.: Наука, 1982.
6. Рассадин В. И. Сложение группы непроеизводных субстантивов в бурятском языке // История развития бурятского языка: сб. ст. – Улан-Удэ : Изд-во БНЦ СО РАН, 2006. – С. 3–16.
7. Рассадин В. И. Очерки по морфологии и словообразованию монгольских языков. – Элиста: Изд-во КГУ, 2008.
8. Севортян Э. В. Выпадение согласных в южных тюркских языках // Исследования по сравнительной грамматике тюркских языков. Ч. 1. Фонетика. – М.: Изд-во АН СССР, 1955. – С. 289–292.

9. Юнусалиев Б. М. Заметки о выпадении некоторых согласных в основах слов тюркских языков // Вопросы диалектологии тюркских языков. Т. IV. – Баку: Изд-во АН Азербайджанской ССР, 1966. – С. 23–34.

10. Poppe N. N. Introduction to Mongolian comparative studies. – Helsinki, 1987.

#### *Эх бичгүүд*

1. МА – Поппе Н. Н. Монгольский словарь Мукаддимат ал-Адаб, ч. I-II. Труды Института востоковедения [АН СССР], XIV. – М.-Л.: Изд-во Акад. наук СССР, 1938.
2. ССТМЯ, 1977 – Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков. – Л. : Наука, 1977. – Т. II.
3. ЭСТЯ, 1989 – Этимологический словарь тюркских языков. Общетюркские и межтюркские лексические основы на «Ж», «Ж», «Й» / Авт. сл. статей Э. В. Севортян, Л. С. Левитская. – М.: Наука, 1989.
4. ЭСТЯ, 1997 – Этимологический словарь тюркских языков. Общетюркские и межтюркские лексические основы на буквы «К», «К» / Авт. сл. статей Л. С. Левитская, А. В. Дыбо, В. И. Рассадин. – М.: Языки русской культуры, 1997.
5. ЭСТЯ, 2003 – Этимологический словарь тюркских языков. Общетюркские и межтюркские основы на буквы «Л», «М», «Н», «П», «С». – М.: Восточная литература РАН, 2003.
6. EDAL – Starostin S. Etymological Dictionary of the Altaic Languages / S. Starostin, A. Dybo, O. Mudrak (with assistance of Ilya Gruntov and Vladimir Glumov). – Leiden; Boston: Brill, 2003.
7. НУ (Houa-yi yi-yu) – Lewicki M. La langue mongole des transcriptions chinoises du XIV-e siècle. Le Houa-yi yi-yu de 1389. – Wrocław, 1949.
8. ИМ – Battal Aptullah. Ibnü-Mühenna lûgati. – Istanbul, 1934.
9. Кow. – Kowalewski J. E. Dictionnaire mongol-russe-français. – Kasan : Imprimerie de l'Université, 1849. – V. I-III.
10. Less. – Lessing F. D. Mongolian-English dictionary. – Berkeley – Los Angeles: University of California Press, 1960.
11. LH – Poppe N. Das mongolische Sprachmaterial einer Leidener Handschrift // ИАН СССР. – 1927. – XXI. – Сер. VI. – № 15–17.
12. SH – Haenisch E. Wörterbuch zu Manghol-un Niuča Tobčaan (Yüan-ch'ao pi-shi), Geheime Geshichte der Mongolen / E. Haenisch. – Leipzig, 1939.
13. Tum. – Tumurtogoo D. Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XVI centuries) Introduction, Transcription and Bibliography, Academia Sinica, Institute of Linguistics / D. Tumurtogoo, G. Cecegdari. – Taipei, Taiwan, 2006. (Language and Linguistics Monographs Series A 11).

#### **ABSTRACT**

The article deals with the historical process of dropping of consonant [r] in root morphemes. It took place at the early study of Mongolian languages' development and was more active then it could be supposed. The author proposes etymologies for some words on the base of sense perception.